



“БОГД БАНК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН ЭРДЭНЭ ОВОГТОЙ БЯМБАЖАВЫН 2025 ОНЫ 1-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргаар болон эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн тухай хууль, банкны тухай хууль, Богд банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

НЭГ. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хуралд оролцсон тоо: 15

Хэлэлцсэн асуудал: 28

2025 оны 1 дүгээр улиралд Төлөөлөн удирдах зөвлөлийн 15 хуралд цахимаар болон танхимаар оролцож хурлаар хэлэлцсэн 28 асуудлаар саналаа хурлын тэмдэглэлд товч бичиж, хурлын шийдвэрт тусгуулан ажилласан.

ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛИЙН ХОРОО

Нийт хуралдсан тоо: 2

Хэлэлцсэн асуудал: 4

2025 оны 1 дүгээр улиралд Эрсдэлийн удирдлагын хороо 2 удаа хуралдаж 4 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

2025 оны 1-р улирал				Санал өгсөн
1	2025.01.06	25/01	1. Богд банкны МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагааны тайлан 2. Эрсдэлийн аппетитийн гүйцэтгэл 2024 он	Дэмжсэн
2	2025.02.17	25/02	1. Богд банкны Комплайнс бодлого батлах тухай 2025 оны Эрсдэлийн аппетитийг батлах тухай 2. Богд банкны Чанаргүй активыг бууруулах стратеги 2025 он	Дэмжсэн

ГУРАВ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРОО

Нийт хуралдсан тоо: 1

Хэлэлцсэн асуудал: 4

2025 оны 1 дүгээр улиралд Аудитын хороо 1 удаа хуралдаж 4 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

2025 оны 1-р улирал				Санал өгсөн
1	2025.01.06	25/01	1. ДАГ 2024 оны ажлын гүйцэтгэл 2. ДАГ-ын 2025 оны ажлын төлөвлөгөө 3. ТУЗ-өөс ДАГ-т өгч 2024 онд гарсан тогтоолын заалтын биелэлт, цаашдын зорилт 4. ТУЗ-ийн шийдвэрээр банк худалдан авсан болон орон сууц, барилга, үндсэн хөрөнгийн тухай	Дэмжсэн

ДӨРӨВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Мөн хугацаанд Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй 3 удаагийн хэлцэлд оролцож өөрийн саналыг өгч, сонирхлын зөрчилтэй хэлцлийг тухайн асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэж ажилласан.

“БОГД БАНК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН ЭРДЭНЭ ОВОГТОЙ БЯМБАЖАВЫН 2025 ОНЫ 1-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”

2025 оны 1-р улирал				Санал өгсөн
1	2025.01.31	25/12	Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай /Бодь цамхаг ХХК-тай холбоотой шугамын зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай/	Дэмжсэн
2	2025.03.10	25/22	Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай /Бодь цамхаг ХХК-тай банкны үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн хүрээнд түрээсийн гэрээ байгуулах тухай/	Дэмжсэн
3	2025.03.18	25/23	Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай /Бодь даатгалтай мэргэжлийн хариуцлагын даатгалтай гэрээ байгуулах тухай/	Дэмжсэн

ТАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ХУВЬД:

Богд банк ХК нь Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу банкны засаглалыг хэрэгжүүлэн хангалттай сайн ажиллаж байна. Удирдлагын баг, ТУЗ-ийн гишүүд, Хувьцаа эзэмшигчдийн хооронд харилцааны үл ойлголцол байхгүй, банкны шийдвэр гаргалт нэг албан тушаалтны хэт төвлөрөлгүйгээр зохих журмын дагуу явагдаж байна. Миний бие ТУЗ хараат бус гишүүнээр ажиллах үед Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь үүсээгүй болно.

Заавал мөрдөх ёстой аливаа хууль, дүрэм журмыг зөрчсөн болон харилцагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхүйц шийдвэр, үйлдэл банкны үйл ажиллагаанд гараагүй болно гэж үзнэ. Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох чөлөөлөх журмын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2025 оны 1 улирлын товч тайланг бэлдэн хүргүүлэв.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
2025.04.01

Э.Бямбажав.

